



## **“БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХХVIII ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

### **“Баянгол зочид буудал” ХК-ийн 2021 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит 28 дугаар хурлын протокол**

*Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2021 оны 4 сарын 28 өдөр 15.00 цагаас Баянгол рестораны заалнаас цахимаар хуралдлаа.*

*Цахим хурал урьдчилан мэдээлэгдсэний дагуу facebook - bayangolhotel –хуудсаар дамжуулан лайваар шууд явагдаж хадгалагдсан болно.*

Хуралд ТУЗ-ийн дарга Д.Аюуш, ТУЗ-ийн гишүүн З.Цэрэнчимэг, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Р.Цогзолмаа, Компанийн гүйцэтгэх захирал Х.Цэндбаяр, Ерөнхий менежер Х.Өнөржаргал, БМАлбаны ахлах менежер Т.Дөлгөөн, ХНАхлах менежер Т. Орхон нар оролцов.

Хурлын Тооллогын комиссын дарга Д.Самданжамц нь Корона вирусын тусгаарлалтанд орсны улмаас хуралд оролцох боломжгүй болсон тул Тооллогын комиссын гишүүн Т.Орхон тооллогын комиссын даргыг орлон гүйцэтгэх болсныг мэдээлэв.

#### **Тооллогын комиссын гишүүн Т. Орхон:**

Хурлын саналын ирц 78.5%–иар бүрдсэнийг мэдээлээд, Тооллогын комиссын тогтоолыг уншиж танилцуулав.

#### **Хурлын дарга З.Цэрэнчимэг:**

Хурлын ирц 78.5%–тай болж, Компанийн тухай хууль болон компанийн дүрэмд заасны дагуу хурал хүчин төгөлдөр болох хувьд хүрсэн учраас хурлыг нээж, цахим хурлын бэлтгэл ажлууд хэрхэн хийгдсэн талаар товч мэдээлэл өгч, хурлаар хэлэлцэх асуудал, хурлын дэг зэргийг танилцуулав. Хурлын дэгийг дэлгэцээр харуулсан болно.

Энэ удаагийн хурлаар:

1.Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах

2.ТУЗ-ын 2020 оны зардлын төсвийг батлах гэсэн энэ хоёр асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ

Одоо эхний асуудлаар ТУЗ-ын дарга Б.Аюуш ТУЗ-ын дүгнэлтийг танилцуулна.

**Б.Аюуш:** Нийт хуралд цахимаар оролцож буй хувьцаа эзэмшигчиддээ мэндчилгээ дэвшүүе.Дэлхий даяар дэгдсэн цар тахлын энэ үед Засгийн газар, УОК, Эрүүл мэндийн байгууллагуудаас гаргаж байгаа хол хорио, халдвар хамгааллын дэглэмийг чанд баримтлан энэ хүнд цаг үеийг хамтдаа туулна гэдэгт итгэж байгаагаагаар удирдлагын зүгээс дамжуулаарай гэснийг хэлэхэд таатай байна.

Хурлын материалууд 2020 оны Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн хураангуй, санхүүгийн тайлангийн талаар хөндлөнгийн аудитын дүгнэлт зэргийг урьдчилан танилцуулсан байгаа.

Энд дэлгэцээр өгөгдсөн слайдууд дээрээс Компаний эрхэм зорилго, Алсын хараа, Чанарын бодлогоо хэрхэн тодорхойлсныг, санхүүгийн үндсэн үзүүлэлтүүд, ололт амжилт, үр дүнгийн талаар тодорхой мэдээллүүдийг өглөө.

Мөн хөл хорионы цаг үед засгийн газрын бодлого шийдвэртэй уялдуулан авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгсөн болно.

Энэ хугацааг ашиглан Баянгол ресортыг ашиглалтанд оруулахад бараг бэлэн болж байгаа сайн мэдээ байгааг тэмдэглэн хэллээ.

**Р.Цогзолмаа:** Компаний ТУЗ-ийн 2021оны зардлын төсвийг уншиж танилцуулав.

**Х.Өнөжаргал:** Ногдол ашиг хуваарилах талаар ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулав.

**Т.Дөлгөөн:** Цахим комментоор ирсэн санал, асуултууд:

Э. Одонцэцэг, Ц.Аюурзана, Б.Сэлэнгэсайхан нараас ирсэн саналыг уншиж танилцуулав.

Асуулт 1: **Хувьцаа эзэмшигч Алтан-Оч:** Тайланд санхүүгийн баланс тусгагдаагүй байгаа талаар хариулт авмаар байна.

Хариулт: **Б.Аюуш:** Санхүүгийн дэлгэрэнгүй тайланг Аудитлагдаагүй үед нийтэд мэдээлэхийг хуулиар хориглосон байдаг бөгөөд бид уг мэдээллээ оруулах үед Аудитын дүгнэлт ирж амжаагүй байсан болно. Компанийн болон МХБ-ийн веб хуудаснаас ороод танилцах боломжтой

Асуулт 2: **Хувьцаа эзэмшигч Пүрэвсүрэн:** Баянгол Ресорт- д 6.4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийжээ. Хөрөнгийн эх үүсвэр хаанаас гарсан талаар тодорхой болгож өгнө үү.

Хариулт: **Б.Аюуш:** Энэ эх үүсвэрийг зөвхөн энэ онд буй болсноор ойлгож болохгүй. Учир нь энэ бүтээн байгуулалтын үйл ажиллагаа нь бараг 10 аад жил үргэлжилж байгаа үйл явц юм, уг хуримтлагдсан эх үүсвэр нь авлага хэлбэрээр санхүүгийн балансад тусгагдаж явж байгаад энэ жил ТУЗ-ийн шийдвэрээр хөрөнгө оруулалтад шилжүүлэн бүртгэгдсэн юм. Гэхдээ бүрэн ашиглалтанд ортол нэмэлт санхүүжилт хийгдэх шаардлага байгаа. Өөрөөр хэлбэл нэмэлд хөрөнгө оруулалт хийгдэнэ гэсэн үг. Бид бүхий л нөөц бололцоогоо эрэлхийлэн ажиллаж байгаа. Ашиглалтанд орох үед нь өөрийн цахим хуудсаар мэдээлэх болно.

- Өөр ирсэн асуулт байгаа эсэхийг тодруулав. Санал хүсэлт, асуулт ирүүлсэн хувьцаа эзэмшигч нартаа баярлалаа

**Асуулт, хариулт дууссан тул Тооллогын комисс ажиллаж ирсэн саналыг нэгтгэх ажиллагаа боллоо.**

**Т.Орхон:** Тооллогын дүнг асуудал тус бүрээр нэгтгэж нийт ирсэн саналын тоо 299241, үүнээс зөвшөөрсөн санал 100% ирснийг мэдээлээд Тооллогын комиссын тогтоолыг уншиж танилцуулав.

**3.Цэрэнчимэг:** Хурлын дэгийн дагуу ХЭ-ийн ээлжит хурал хүчин төгөлдөр болсныг дурьдаад:

1. Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн баталсан тогтоол

2.ТУЗ-ын 2021 оны зардлын төсвийг баталсан тогтоолыг тус тус уншиж танилцуулав.

Өнөөдрийн хурал амжилттай болж өндөрлөлөө. Хурал хаасныг мэдэгдье.  
Та бүхэнд эрүүл байж ковидгүй сайхан цагыг угтаж, бид зочин гийчдээ хүлээн авч  
хөгжлийн төлөө хамтдаа байхыг ерөөе. Эрхэм хувьцаа эзэмшигч та бүхэндээ  
Баярлалаа.

Хурлын дарга



З.Цэрэнчимэг

Протокол хөтлөсөн

Р.Цогзолмаа